



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

"УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2024/18-03-ШТА-ГА

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ЯВУУЛАХ ОРЧИН НӨХЦӨЛ САЙЖИРЧ БАЙГАА БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ ХУУЛЬД ЗААСАН  
ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАХГҮЙ БАЙХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ  
СУЛААС ХӨРӨНГИЙН ҮР АШИГ БУУРЧ, ТӨСВИЙН ЗАРДАЛ НЭМЭГДЭЖ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу  
Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Ахлах аудитор **М.Алтантуяа**

Утас: 70442424 цахим хуудас: [Altantuyam@audit.gov.mn](mailto:Altantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор **Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)

Аудитор **Н.Батчимэг**

Утас: 91113253 цахим хуудас: [Batchimegn@audit.gov.mn](mailto:Batchimegn@audit.gov.mn)

Баянхонгор хот 2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.tailan.audit.mn](http://www.tailan.audit.mn)

**Тайланг хянасан**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Ахлах аудитор М.Алтантуяа

**Тайланг бэлтгэсэн:**

Ахлах аудитор Б.Азбаяр  
Аудитор Н.Батчимэг

2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр

Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

**ХАЯГ:**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,  
Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум 64090,  
Баянхонгор аймаг  
Монгол Улс

**АГУУЛГА**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....3

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ .....4

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: .....4

БҮЛЭГ А. ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ ХИЙГЭЭГҮЙ БАЙХАД ТӨСӨВ БАТАЛСНААС ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ХҮНДРЭЛ УЧИРЧ БАЙНА. ....5

А.1. Төсвийн тухай хуулийг зөрчин орон нутгаас санал өгөөгүй, ТЭЗҮ хийгээгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээг баталснаас тайлант хугацаанд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж, төсвийн ачаалал нэмэгдэх, төсвийн үр ашгийг бууруулах эрсдэл нэмэгдэж байна. ....5

А.2. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг жигд бус хуваарилсан нь ажлын чанар болон үр дүнд нөлөөлж болзошгүй эрсдэл үүсгэж байна. ....6

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон ба санхүүжүүлэх нөөцийг бүрэн ашиглаагүй байна. ....7

БҮЛЭГ Б. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САНХҮҮЖИЛТТЭЙ УЯЛДУУЛАН ОЛГОСНООР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ САЙН БАЙГАА Ч ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА ХЭТЭРСЭН, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ ЗӨРЧИЛ ИЛЭРЧ БАЙНА. 11

Б.1 Баянхонгор аймагт 2023 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт дундаж гүйцэтгэл 81.4 хувьтай байна. ....11

Б.2. Төсөл арга, хэмжээнд хууль тогтоомжийн дагуу хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч ашиглалтад орсны дараа зөрчил, дутагдал гарч байгаагаас үзэхэд хяналтыг сайжруулах шаардлагатай байна. ....15

Б.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэн ашиглалтад оруулсан зарим барилгыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна. ....16

БҮЛЭГ В. БАЯНХОНГОР АЙМАГТ ХЭРЭГЖИЖ АШИГЛАЛТАД ОРСОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНД АЯ ТУХТАЙ, ТААТАЙ ОРЧИНД 1,906 ХҮҮХЭД СУРЧ, 130 ХҮҮХЭД АМЬДАРЧ, 3,868 ХҮН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АВЧ, ХҮҮХДҮҮД БОЛОН ИРГЭД УСАН БАССЕЙН СПОРТ ЦОГЦОЛБОРТ 10 ТӨРЛИЙН СЕКЦ ДУГУЙЛАНД ХАМРАГДАХ БОЛОМЖ БҮРДСЭН БАЙНА. ....19

В.1. Баянхонгор аймагт УТХО-аар 2023 онд хэрэгжиж байнгын ашиглалтад орсон 14 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. ....19

В.2. УТХО-аар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, зарим төсөл, арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн байна. ....20

ДҮГНЭЛТ: .....35

ЗӨВЛӨМЖ: .....36

УАГ-ын Гүйцэтгэл, Нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал .....37

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, борилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОН	Орон нутаг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт	5
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа	8
Хүснэгт 3	Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт	9
Хүснэгт 4	УТХО-аар Баянхонгор аймагт нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж	17
Хүснэгт 5	УТХО-аар боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт	20
Хүснэгт 6	Он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ	23
Хүснэгт 7	Орон нутгийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа	24
Хүснэгт 8	Төсөл, арга хэмжээний санхүүжилт	25
Хүснэгт 9	Авто замын сангийн ТАХ-ний санхүүжилт	26
Хүснэгт 10	Боловсролын салбарт хийсэн хөрөнгө оруулалт	33

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын нэгдсэн тайланд нэгтгүүлэх болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

- Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
  - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
  - Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийв.

Аудитад УТХО-аар 2023 онд Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 131,153.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 45,192.7 сая төгрөгөөр санхүүжих 22 төсөл арга хэмжээг хамруулав.

Аудитын хязгаарлалт

Аудитад Монгол Улсын 2023 онд төсвийн тухай хуулиар батлагдаж аймгийн ТЕЗ-чид эрх шилжиж ирсэн болон аймгийн ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс бусад эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээг хамруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Н.Батчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Хүндрэл  
бэрхшээл

Аудитын талбарын үе шатны ажлыг 2023 оны 03 дугаар сарын 26-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад дэд тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 05 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.  
Байхгүй

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### ***Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:***

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт хэрэгжихээр өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 184,673.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 62,652.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан ба тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ батлаагүй байна.

Дээрх 37 төсөл арга хэмжээнээс 131,153.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 45,192.7 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

### ***Орон нутгийн хөрөнгө оруулалтаар:***

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 оны их засварын жагсаалтыг батлахдаа өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 1,960.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,085.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 ТАХ, тайлант онд шинээр эхлэх 583.1 сая төгрөгийн өртөг бүхий 438.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 ТАХ хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2023 онд 501.2 сая төгрөгийн 105.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг өмнөх оноос шилжин, 1,442.0 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн санхүүжүүлэхээр баталсан байна.

Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар 274.9 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг тодотгон баталжээ.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

### ❖ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХОЛБОГДОХ ТООЦООЛОЛ, БАРИМТ БИЧГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛЖ, САНХҮҮЖҮҮЛСЭН ҮҮ? ОРОН НУТГААС САНАЛ ӨГӨӨГҮЙ, ТЭЗҮ ХИЙГЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ТӨСӨВ БАТАЛЖ САНХҮҮЖҮҮЛСЭН НЬ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНДРЭЛ УЧРУУЛЖ БАЙНА.**

**А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан уу?**

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн ТАХ-ээс Төсвийн тухай хуулийг зөрчин орон нутгаас санал өгөөгүй 1, ТЭЗҮ хийгээгүй, магадлалаар баталгаажуулах 3 төсөл арга хэмжээг баталсан байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж буй төсөл, арга хэмжээний архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймгийн ерөнхий архитектор гарган баталгаажуулсны үндсэн дээр техникийн нөхцөл олгох, зургийн даалгавар боловсруулах үйл явц хийгдэж байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх нийтлэг дүрмийн 3.3<sup>1</sup>-т заасан шаардлагад нийцэж байна.

Гэвч зарим төсөл арга хэмжээний хувьд төсөв баталсны дараа архитектор төлөвлөлтийн даалгаврыг боловсруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан 29.4<sup>2</sup> заасан заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

- Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ арга хэмжээ нь 2022 оны улсын төсөвт 2021 оны 11-р сард баталсан байхад 2022 оны 3 дугаар сард архитектур төлөвлөлтийн даалгаврыг хийсэн нь төлөвлөлтийн дараалал алдагдсан байна..

Хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулаагүй, урьдчилан тоо хэмжээг тооцоогүйгээр хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж баталснаас шалтгаалан төсөв нэмэгдэх гол шалтгаан болж байна. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

- "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/-ийн төсөл, арга хэмжээг зураг төсөв хийгдээгүй байхад анх 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж байсан бол зураг төсөв хийж, төсөвт магадлал хийлгэснээс шалтгаалан 2023 онд төсөвт өртөг 4,960.8 сая төгрөгөөр нэмэгдэж 9,960.8 сая төгрөг болж нэмэгдсэн
- Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/ төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй байхад МУ-ын 2021 оны төсвийн тухай хуульд төсөвт оруулан анх 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан бөгөөд 2023 онд ажлын зураг төсвийг магадлалаар оруулснаар инженерийн шугам сүлжээний ажил 7,762.4 сая, авто замын ажил 4,153.5 сая төгрөг болж нийт 11,915.9 сая төгрөг болж нэмэгдсэн

<sup>1</sup> Энэ дүрмийн 3.2-т заасан шийдвэрийг гаргахад аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалт, газрын харилцааны асуудал хариуцсан нэгж нь дараах асуудлыг тусгасан архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулна:

<sup>2</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Дээрх төсөл арга хэмжээнүүд нь төсөвт баталсан тухайн онд зураг төсөв байхгүйгээс түлхүүр гардуулах нөхцөлөөр ажлын тоо хэмжээ гарган худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ба захиалагчийн зүгээс гаргасан ажлын тоо хэмжээг үндэслэн зураг, төсөв хийлгэн батлуулж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэж улсын төсөвт ачаалал болох эрсдэл үүсэж байна.

Баацагаан сумын төсвийн шинэчлэл төсөл, арга хэмжээ нь магадлалаар төсөв нэмэгдсэн боловч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт нь тусаагүйгээс уг арга хэмжээ удаашрах үр дагавартай байна.

Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулдаг байдлыг таслан зогсоохыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

Ингэний сүүний үйлдвэрийн барилга нь үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах явцад барилгад өргөтгөл хийх шаардлага үүсэж зохиогчийн зөвшөөрлөөр өргөтгөл нэмж барьсан байна. Гэвч тухайн өргөтгөлийн барилга нь гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр хийсэн гэх боловч төр хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээ, баримт бичиг байхгүй, төсөв магадлалаар орж байгаа талаар тайлбар өгсөн боловч ямар нэгэн нотлох баримт байхгүй байна.



Ингэний сүүний үйлдвэрийн өргөтгөлийн барилгын хэсэг

Иймээс дээрх хөрөнгө оруулалтын нэмэгдсэн өртгийг мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зөвлөмжийн аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст хүргүүлэв.

***А.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?***

***Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг жигд бус хуваарилсан нь 3 төсөл арга хэмжээний ажлын чанар болон үр дүнд нөлөөлж болзошгүй эрсдэл үүсгэж байна.***

МУ-ын 2023 оны төсвийн тухай хуульд шинээр эхлүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байхгүй ба өмнөх оноос шилжин ирсэн 131,153.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл, арга хэмжээг 45,192.7 сая санхүүжүүлэхээр баталсан байна.

Дээрх баталсан 22 төсөл арга хэмжээнээс 79,896.0 сая төгрөгийн өртөгтэй 29,510.6 мянган төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл арга хэмжээг хэрэгжих бололцоотой буюу 2-3 жилд багтаан санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Харин Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>3</sup>-д шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлэхээр заасан байхад баталсан санхүүжилтийн 2 жилийн нийлбэр тухай төсөвт өртгийн 50 хувьд ч хүрээгүй дараах 3 ажлыг баталсан байна. *Тухайлбал:*

**Хүснэгт№1. Төсөл арга хэмжээний санхүүжих дүнгийн талаар**

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	2022		2023		2 Жилд нийт баталсан санхүүжих дүн	Төсөвт өртөгт эзлэх хувь
	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн		
Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	27,000.0	2,400.0	25,328.3	6,425.6	8,825.60	34.84
Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/	10,000.0	480.0	10,000.0	4,201.4	4,681.40	46.81
110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/	14,003.6	2,453.6	13,296.7	3,530.4	5,984.00	45.00
	51,003.6	5,333.6	48,625.0	14,157.4		

Санхүүжих дүнг олон жилд хувааж олгох нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удааширч чанаргүй болох, төсөв нэмэгдэх, төлөвлөсөн ажил орхигдох үр дагавартай байна.

Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дунд хугацаанд жигд хуваарилах бодлого барьж ажиллах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллага албан тушаалтанд уламжлах талаар ҮАГ-ын ГНАГ-т санал хүргүүлэв.

**А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?**

**Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.**

Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжсэн 22 төсөл, арга хэмжээний нийт 34 багц ажилд 42,305.8 сая төгрөгийн санхүүжилтийг 2023 онд аймгийн Төрийн сангийн дансаар дамжуулан олгосон байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин ирсэн дүнгээр авч үзвэл:

<sup>3</sup> шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

**Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа**

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан дүн	Нийт олгосон санхүүжилт	2023 онд олгосон санхүүжилт	Санхүүжүүлсэн хувь
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баацагаан сум/	"Бианконэро констракшн" ХХК	1,560.7	1,560.7	360.7	100%
2-1	Багийн засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж Багц 1-Мотоцикл нийлүүлэх ажлын санхүүжилт	"Бүдума" ХХК	214.8	214.8	103.2	100%
2-2	Багц 2 Зөөврийн компьютер, принтер нийлүүлэх ажлын санхүүжилт	"Хаш Лотус" ХХК	84.3	84.3	46.3	100%
3	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/	"Саммит компьютер технологи" ХХК	403.7	403.7	53.7	100%
4	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/	"РИНО ИНЖЕНЕРИНГ" ХХК	4,995.0	2,211.2	2,211.2	44%
5	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	"Б СОФТ" ХХК	25,328.3	8,825.6	6,425.6	35%
6	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	"Гал хонгор" ХХК	6,961.1	5,922.0	5,442.0	85%
7	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	"АЛЕГРОТОВЕР" ХХК	9,960.8	5,766.7	1,000.0	58%
8	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"ЖАМЪЯН ПАЙТАН" ХХК	1,316.3	1,313.9	16.3	100%
9	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	"Навтгар хайрхан" ХХК	5,284.0	3,662.9	1,069.6	69%
10	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	Хөх бүрдний эх ХХК	5,145.4	5,145.4	50.1	100%
11	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/	"Зүүн шанд" ХХК	2,042.0	2,042.0	452.2	100%
12	Сургуулийн барилгын өргөтгөл, 440 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/	"Эх бүрдэн" ХХК	5,467.9	5,447.7	1,845.4	100%
13	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/	Шинэ өлгийн зам ХХК	1,799.1	1,269.6	1,129.6	71%
14	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/	Саммит компьютер технологи	1,479.0	1,479.0	1,171.0	100%

15	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	"Ган мөнхжин"ХХК	1,925.9	1,925.9	179.2	100%
16	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	ТҮМ ДЭЛГЭРЭХ	7,995.2	4,614.5	2,814.5	58%
17-1	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах ажлын гүйцэтгэл- Ингэний сүүний үйлдвэр	Базардарь ХХК	3,848.1	3,848.1	2,734.6	100%
17-2	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах	НЬЮ БЕСТ ХАУС ХХК	808.1	808.1	308.1	100%
17-3	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах- шинэ суурьшлын бүсийн цахилгааны эх үүсвэрийн материал	ЭН ДИ ЭМ ЭМ ХХК	1,195.0	1,195.0	458.6	100%
17-4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 2/ Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил	БЭНЖЦЭС ХХК	2,584.8	1,584.8	1,584.8	61%
17-5	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 3/ Мах ногооны 1000 тн зоорины барилга	САНТ-ӨНДӨР ХХК	3,074.9	3,054.9	1,873.9	99%
17-6	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж	Алтайн эколог ХХК	450.0	450.0	-	100%
18-1	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл -ХАА МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	ЭМ ЭН ЮУ ХХК	2,835.2	992.2	940.2	35%
18-2	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 1: ХАА кластерийн барилга байгууламжийн ажил	ТАТАХ ХҮЧ	3,315.1	1,490.0	1,390.0	45%
18-3	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 2: Гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажил	НОМГОНЫ АНДУУД	373.9	373.9	323.9	100%
18-4	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 5: ХАА кластерийн гадна тохижилт хүрмэн бетон хашааны ажил	ГИЧГЭНЭ ХЯР ХХК	1,174.0	974.0	724.0	83%
18-5	ЕЛБАТА, РИМ2300280475, XIII.1.15-6, Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ (Багц-6) Хүлэмжийн барилгын ажил	"ГАРЬД СИСТЕМС" ХХЪ	1,678.0	760.0	760.0	45%

18-6	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/Багц3. ХАА кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл: Дэд станц, Баянлиг сумын тариалангийн талбайн цахилгааны дэд станц барих ажил,	"ЕЛБАТА" ХХК	191.3	91.3	63.3	48%
19	110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/	"ДМТМ ТРЕЙД" ХХК	13,296.7	5,984.0	3,530.4	45%
20	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/	"Зураан даваа" ХХК	1,670.4	1,466.5	149.2	88%
21-1	Сумдын эрүүл мэндийн төвийн багийн эмч нарт 49 ш мотоцикл нийлүүлэх	"Бүдума" ХХК	137.7	137.7	45.7	100%
21-2	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх	"РЕСЕНГ МЕД" ХХК	312.0	312.0	104.0	100%
22	Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	"РМВ" ХХК	11,899.4	11,899.4	2,944.4	100%
НИЙТ			130,808.3	87,312.1	42,305.8	81.4

Эх сурвалж: Санхүүжилт олгосон гүйцэтгэлийн баримт бичгээс

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын нийт санхүүжих дүн 45,192.7 сая төгрөгөөс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дансаар нийт 41,236.2 сая төгрөгийн эрх нээлгэж төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн ба 3,956.5 мянган төгрөгийн санхүүжих боломжийг алдсан байна.



Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан хөрөнгийг бүрэн ашиглахад анхаарч тайлант онд төлөвлөсөн ажлыг бүрэн хийлгэх, хугацааг баримтлахад хяналтаа сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

**БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ, ХҮЛЭЭН АВСАН УУ?**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙСЭН 22 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС 3 НЬ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.**

**Б.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?**

**Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн 4 багцын ажлыг хэрэгжүүлэхдээ сонгосон байршлын геологийн дүгнэлтийг харгалзаагүйгээс барьсан объектууд эвдэрсэн байна.**

2023 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 22 төсөл, арга хэмжээний 34 багцаас барилга байгууламж 27, тоног төхөөрөмж 7 ажил байна.

*Хүснэгт №3. Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт*

№	Төсөл арга хэмжээний нэр	Нөхцөл байдал
1	Баацагаан сумын Засаг даргын тамгын газрын барилгын ажлын гүйцэтгэл Гэрээний дүн: <b>1,560.7 сая</b> Гүйцэтгэгч: "Бианконэро констракшн" ХХК Гүйцэтгэл: <b>100 хувь</b>	Улсын комисс ажиллаж хүлээж авсан боловч улсын комиксоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй. Барилгын зарим хэсэгт халдаггүй, вакум цонх чигжээс муу хийснээс дулаан алддаг, цахилгааны монтаж зарим хэсэгтээ ажиллагаагүй, дотор сангаас ус тусдаг
2-1	Багийн засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж Багц 1- Мотоцикл нийлүүлэх ажлын санхүүжилт. Гэрээний дүн: <b>214.8 сая</b> Гүйцэтгэгч: "Бүдума" ХХК Гүйцэтгэл: <b>100 хувь</b>	Мотоциклыг хүлээн авсан. Зарим мотоциклыг улсын дугаар аваагүй.
2-2	Багц 2 Зөөврийн компьютер, принтер нийлүүлэх ажлын санхүүжилт Гэрээний дүн: <b>84.3 сая</b> Гүйцэтгэгч: "Хаш Лотус" ХХК Гүйцэтгэл: <b>100 хувь</b>	Тоног төхөөрөмжийг жагсаалтаар хүлээн авсан.
3	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: <b>403.7 сая</b> Гүйцэтгэгч: "Саммит компьютер технологи" ХХК Гүйцэтгэл: <b>100 хувь</b>	Тоног төхөөрөмжийг жагсаалтаар хүлээн авсан.
4	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/ Гэрээний дүн: <b>4,995.0 сая</b> Гүйцэтгэгч: "Рино инженеринг" ХХК Гүйцэтгэл: <b>44.3 хувь</b>	Бохир усны шугам хоолойн ажил хийсэн. Цэвэр ус, халаалтын шугамын ажил хийж байгаа. Авто замын ажил эхлээгүй, ажил удаашралтай.
5	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: <b>25,328.3 сая</b> Гүйцэтгэгч: "Б софт" ХХК Гүйцэтгэл: <b>34.8 хувь</b>	Баянхонгор аймгийн гэр хорооллын 2,7,9 дүгээр багт ус хангаж, ариутгах татуургын ажлыг төлөвлөсөн хэмжээнд хийсэн 3-р багт гадна дулаан хангамж 100 хувь, 4,5 дугаар багт 39 хувь, 6 дугаар багт цэвэр усан хангамжийн ажил 97 хувь хийсэн. Ажлын явцад мэргэжлийн хөндлөнгийн шинжээч ажиллуулах шаардлагатай байна.
6	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: <b>6,961.1 сая</b> Гүйцэтгэгч: "Гал хонгор" ХХК Гүйцэтгэл: <b>50 хувь</b>	Ариутгах татуургын ажил 88 хувь, усан хангамж, гадна дулааны ажил 50-60 хувийн гүйцэтгэлтэй байна. Одоогийн байдлаар цэвэрлэх байгууламж, шүүрүүлэх талбай, ус түгээх байрын ажил эхлээгүй байна.
7	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/ Гэрээний дүн: <b>9,960.8 сая</b> Гүйцэтгэгч: "Алегротонер" ХХК Гүйцэтгэл: <b>57.9 хувь</b>	Цэвэр усан хангамжийн болон гадна дулааны ажил хийсэн, авто зам болон дугуйн зам, гэрэлтүүлгийн ажил 81 хувийн гүйцэтгэлтэй. Одоогийн байдлаар Цэвэрлэх байгууламжийн болон ариутгах татуургын ажил хийгдээгүй байна. Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гарсан.
8	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/ Гэрээний дүн: <b>1,317.0 сая</b> Гүйцэтгэгч: "Жамъянпайтан" ХХК Гүйцэтгэл: <b>100 хувь</b>	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг тайлангийн В.1 хэсэгт дурдав.
9	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/ Гэрээний дүн: <b>5,284.0 сая</b>	Барилгын суурь тавигдаж хана өрлөг, хийгдсэн хучилтын ажлыг барилгын зарим хэсэгт хийсэн. Гадна

	Гүйцэтгэгч: "Навтгар хайрхан" ХХК Гүйцэтгэл: 69.3 хувь	шугам сүлжээний ажил хийж байгаад орхисон. 2023 онд барилгын ажил хийгээгүй. Барилга удаашралтай,
10	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/ Гэрээний дүн: 5,216.2 сая Гүйцэтгэгч: " Хөх бүрдний эх" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг өмнөх аудитаар албан шаардлага өгсөн ба биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.
11	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/ Гэрээний дүн: 2,042.0 сая Гүйцэтгэгч: " Зүүн шанд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг тайлангийн В.1 хэсэгт дурдав.
12	Сургуулийн барилгын өргөтгөл, 440 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/ Гэрээний дүн: 5,467.9 сая Гүйцэтгэгч: " Эх бүрдэн " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг өмнөх аудитаар албан шаардлага өгсөн ба биелэлтийг тооцсон. Барилгын анхны төсвөөс гадна фасадын ажлыг өөрчилсөн.
13	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/ Гэрээний дүн: 1,801.0 сая Гүйцэтгэгч: " Шинэ өлгийн зам " ХХК Гүйцэтгэл: 70.6 хувь	Барилгын үндсэн бүтээцийн ажил хийсэн, дотор заслын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын ажлын явц 80-90 хувьтай 2024 оны 6 дугаар сард ашиглалтад өгөх төлөвлөгөөтэй талаар барилгын инженер тайлбар өгсөн. Дотор халаалт, цахилгааны ажил хийсэн.
14	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 1,479.0 сая Гүйцэтгэгч: " Саммит компьютер технологи " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тоног төхөөрөмжийг жагсаалтаар хүлээн авсан.
15	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/ Гэрээний дүн: 1,926.0 сая Гүйцэтгэгч: " Ган мөнхжин " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилга ашиглалтад орсон ба цонхны чигжээс муу хийснээс дулаан алддаг, өрөөнд секц цөөхөн байгаагаас барилга ерөнхийдөө сэрүүн.
16	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 7,995.2 сая Гүйцэтгэгч: " Түм дэлгэрэх " ХХК Гүйцэтгэл: 57.7 хувь	Замын трассын дагуу хайрган хучилт хийсэн ба зохиогчийн хяналтын дүгнэлтээр хайрганы ангилал зөрсөн ба Шинэ суурьшлын бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын аудитаар албан шаардлага өгсөн биелэлт тооцох хугацаа болоогүй.
17-1	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах ажлын гүйцэтгэл- Ингэний сүүний үйлдвэр Гэрээний дүн: 3,848.1 сая Гүйцэтгэгч: " Базардарь " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Ингэний сүүний үйлдвэрийн барилгыг ашиглалтад хүлээн авсан байсан боловч тоног төхөөрөмжийг суурилуулах явцад өртгөтөл хийх шаардлага үүсэж өртгөтөл хийсэн. Нэмэгдэл төсөв шаардагдаж зураг төсвийг магадлалаар баталгаажуулах ажил хийж байгаа.
17-2	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Гэрээний дүн: 808.1 сая Гүйцэтгэгч: " Нью бест хаус " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гадна холбооны ажлыг хийж гүйцэтгэсэн ба Шинэ суурьшлын бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын аудитаар дутуу ажлыг гүйцээх албан шаардлага өгсөн ба биелэлт тооцох хугацаа болоогүй.
17-3	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах- шинэ суурьшлын бүсийн цахилгааны эх үүсвэрийн материал Гэрээний дүн: 1,195.0 сая Гүйцэтгэгч: " ЭН ДИ ЭМ ЭМ " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Цахилгааны материалыг нийлүүлсэн ба аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК ажлыг хийж гүйцэтгэсэн.
17-4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 2/ Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил Гэрээний дүн: 2,584.8 сая Гүйцэтгэгч: " БЭНЖЦЭС " ХХК Гүйцэтгэл: 61.3 хувь	Тус арга хэмжээ нь өвлийн 3 хүлэмж барих ажил бөгөөд 2 хүлэмжийг барьж дуусгасан, 2024 онд үлдэгдэл 1 хүлэмж баригдахаар төлөвлөсөн.
17-5	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 3/ Мах ногооны 1000 тн зоорийн барилга Гэрээний дүн: 3,074.9 сая Гүйцэтгэгч: " Сант-Өндөр " ХХК Гүйцэтгэл: 80-90 хувь	Тус зоорины барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн ба тоноглох ажил хийгдэж байна. Тус барилгыг сэндвичээр барьсан.
17-6	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж Гэрээний дүн: 450.0 сая Гүйцэтгэгч: " Алтайн эколос " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Цэвэрлэх байгууламжийг ТОПЭРО төхөөрөмжийг суурилуулан хүлээлгэн өгсөн.
18-1	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл -ХАА МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ Гэрээний дүн: 2,835.2 сая Гүйцэтгэгч: " ЭМ ЭН ЮУ " ХХК Гүйцэтгэл: 35 хувь	Тоног төхөөрөмжийн эхний хэсэг ирсэн ба бүрэн хүлээлгэн өгч дуусаагүй.
18-2	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 1: ХАА кластерийн барилга байгууламжийн ажил Гэрээний дүн: 3,315.1 сая Гүйцэтгэгч: " Татах хүч " ХХК	Сэндвичээр ногоон тэжээлийн үйлдвэрийн барилгыг барьсан, Авто гражын барилын төмөр каркасны угсралт хийсэн, ажилчдын байрны суурийн ажлыг хийсэн, агуулахын барилгыг барьсан байна.

Гүйцэтгэл: 44.9 хувь		
18-3	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 2: Гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажил Гэрээний дүн: 373.9 сая Гүйцэтгэгч: " Номгоны андууд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гүн өрмийн худгийг ажил бүрэн хийсэн байна.
18-4	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 5: ХАА кластерийн гадна тохижилт хүрмэн бетон хашааны ажил Гэрээний дүн: 1,174.0 сая Гүйцэтгэгч: " Гичгэнэ хяр " ХХК Гүйцэтгэл: 83 хувь	Гадна тохижилтын ажлын шугаман суурьтай блок хашаа хийсэн боловч хөрс намгархаг овой хөлддөг газарт хашаа хийснээс шалтгаалан нэлэнхийдээ ханарч хазайсан, гадна замын суурь хайргыг дэвсгэж бордиур хийсэн боловч мөн газар хөлдөлтөөс хамаарч тэгш бус болсон. Ажилд шинжээч ажиллуулах шаардлагатай.
18-5	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ (Багц-6) Хүлэмжийн барилгын ажил Гэрээний дүн: 1,678.0 сая Гүйцэтгэгч: " Елбата " ХХК Гүйцэтгэл: 45.3 хувь	Нийт 5 өвлийн хүлэмжийн барилга барихаас 2 барилга баригдаж 80-90 хувийн гүйцэтгэлтэй болсон. Үлдсэн 3 хүлэмжийн барилгыг эхлээгүй.
18-6	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/Багц3. Дэд станц, Баянлиг сумын тариалангийн талбайн цахилгааны дэд станц барих ажил Гэрээний дүн: 191.3 сая Гүйцэтгэгч: " Гарьд системс " ХХК Гүйцэтгэл: 47.7 хувь	Дэд станцын ажлыг хийж хүлээлгэн өгсөн.
19	110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/ Гэрээний дүн: 13,296.7 сая Гүйцэтгэгч: " ДМТМ ТРЕЙД " ХХК Гүйцэтгэл: 45.0 хувь	Төсөл, арга хэмжээний хүрээнд 2,316.2 сая төгрөгийн барилгын өргөтгөлийн ажил хийж 38.5 хувийн гүйцэтгэлтэй байна. 9,130.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж суурилагдахаас 5,3605 төгрөгийн төхөөрөмжийг авчирсан суурилуулж эхэлсэн байна.
20	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/ Гэрээний дүн: 1,463.7 сая Гүйцэтгэгч: " Зураан даваа " ХХК Гүйцэтгэл: 87.8 хувь	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг тайлангийн В.1 хэсэгт дурдав.
21-1	Сумдын эрүүл мэндийн төвийн багийн эмч нарт 49 ш мотоцикл нийлүүлэх Гэрээний дүн: 137.7 сая Гүйцэтгэгч: " Бүдума " ХХК Гүйцэтгэл: 100.0 хувь	Мотоциклыг хүлээн авсан. Зарим мотоциклыг улсын дугаар аваагүй.
21-2	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх Гэрээний дүн: 312.0 сая Гүйцэтгэгч: " Ресенг мед " ХХК Гүйцэтгэл: 100.0 хувь	Тоног төхөөрөмжийг жагсаалтаар хүлээн авсан.
22	Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 11,899.4 сая Гүйцэтгэгч: " РМВ " ХХК Гүйцэтгэл: 100 хувь НИЙТ	Барилгын бүрэн хүлээн авч ашиглалтад орсон. Ашиглалтын явцад үүссэн зөрчлийг тайлангийн В.1 хэсэгт дурдав.

Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн 4 багцын ажлыг хэрэгжүүлэхдээ сонгосон байршлын геологийн дүгнэлтийг харгалзаагүйгээс барьсан объектууд эвдэрсэн байна.



Хашаа нэлэнхийдээ хазайсан



Зам хашлага хөрсний овойлтоор хазайсан

### **Анхаарал хандуулах асуудал:**

- Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ болон Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/, Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ арга хэмжээнүүдэд хөндлөнгийн шинжээч ажиллуулах шаардлагатай.
- Баянхонгор аймагт хэрэгжсэн эрх шилжсэн 3 ТАХ, эрх шилжээгүй 1 ТАХ Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд санхүүжих дүн бүрэн баталж дууссан боловч одоогийн байдлаар бүрэн хэрэгжээгүй барилга угсралтын ажил өнөөг хүртэл дуусаагүй байна. Үүнд:

#### Эрх шилжсэн

- Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/-“Навтгар хайрхан” ХХК
- Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/ “Энх баялаг констракшн” ХХК
- Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ - “Стандарт тоосго” ХХК

#### Эрх шилжээгүй

- Дотуур байрын барилга, 150 ор /Баянхонгор, Богд сум/-“Хорол багана констракшн” ХХК

Эрх шилжсэн дээрх 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 527.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан байсныг гүйцэтгэл гараагүйгээс улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүд нь хэрэгжиж эхэлснээс хойш удааширч, гүйцэтгэл зогссон тул 2022 онд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж өгч биелээгүй тул “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар асуудлыг хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлэх албан шаардлага өгсөн боловч, төсөв нэмэгдэж, гэрээний нөхцөл өөрчлөгдөж байгаа гэсэн шалтгаанаар хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй.

Иймд дээрх төсөл, арга хэмжээнүүдийг Боловсролын яам, Барилга хөгжлийн төв, холбогдох хууль хяналтын байгууллагын түвшинд асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

*Б.2. Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан уу?*

**Төсөл арга, хэмжээнд хууль тогтоомжийн дагуу хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч зөрчил дутагдалд хариуцлага тооцохгүй байгаагаас ажлыг чанаргүй хийх байдал давтагдан гарч байна.**

Баянхонгор аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй “Аймагт хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх” гэрээг 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан байна.

Аймгийн ГХБХБГ нь 2023 онд УТХО-аар барилга угсралтын болон байгууламжийн 6 ажилд 35 удаа, хөдөө сумдын 19 ажилд 43 удаа захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Хяналтаар илэрч буй зөрчил дутагдлыг арилгах 159 үүрэг даалгавар, зөвлөмж, зөвлөгөө өгч өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргуулан холбогдох тайлан судалгааг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Барилгын хөгжлийн төвд хүргүүлж ажилласан байна.

УТХО-аар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс 495.1 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс 132.5 сая, уул уурхайн компаниас 4.0 сая төгрөгийн санхүүжилт авч хяналтын зардалд 153.9 сая төгрөг зарцуулсан байна.

Харин 110/35/6 КВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн захиалагчийн хяналтын гэрээг аймгийн Засаг дарга “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” тусгай зөвшөөрөлтэй “Грийн энерги интернэйшнл” ХХК-тай 137.4 сая төгрөгөөр байгуулж захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлж 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Барилга угсралтын гүйцэтгэлийн шатанд 4 удаа үе шатны хяналтаар ажиллаж 7 хоног бүр ажлын гүйцэтгэлийн талаар тайлан авч заавар, зөвлөмж өгч ажилласан байна. Баталсан зургийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэх явцад алдаа, зөрчил гараагүй байна.

Эрдэнэцогт сумын шинэчлэл төслийн 2.5 км хатуу хучилттай автозамын захиалагчийн хяналтын гэрээг 36.3 сая, Галуут сумын шинэчлэл төслийн 2 км хатуу хучилттай автозамын захиалагчийн хяналтын гэрээг 53.7 сая, Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр 126.3 сая төгрөгөөр тус тус “Экситос” ХХК-тай аймгийн Засаг дарга байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

“Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй “Экситос” ХХК нь Эрдэнэцогт сумын шинэчлэл төслийн 2.5 км хатуу хучилттай автозам, Галуут сумын шинэчлэл төслийн 2 км хатуу хучилттай автозам, Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн бөгөөд замын ажлын баталсан зураг төсөл, техникийн шаардлага, гэрээний нөхцөлийн дагуу ажлын график, төлөвлөгөө, технологи аргачлалыг батлуулан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналт хэрэгжүүлэх журам”-ын дагуу заавар зөвлөгөө, албан шаардлага, зөвлөмж өгч биелэлтийг хангуулан ажилласан байна.

УТХО-ын 2023 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээнээс 30,801.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6,145.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 барилга ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллаж барилга байгууламжийг ашиглалтад оруулах 7 дүгнэлт гарч, Баацагаан сумын ЗДТГ-ын барилгад 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр улсын комисс ажилласан боловч комиссын акт эцэслэн гараагүй байна.

*Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?*

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэн ашиглалтад оруулсан зарим барилгыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.**

Баянхонгор аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 30,801.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 барилга ашиглалтад орсноос ТӨБЗГ-ын



шийдвэрээр 1,926.0 сая төгрөгийн 1, аймгийн ИТХ-ын даргын захирамжаар 8,575.2 сая төгрөгийн 3 барилгыг бүртгэх шийдвэр гарч нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн 2023 оны аудитаар 8,730.6 сая төгрөгийн 1 барилгыг бүртгэх албан

шаардлага хүргүүлж, аймгийн ОНӨГ-аас аймгийн ИТХ-д 1,463.7 сая төгрөгийн 1 барилгын эзэмшигчийг тогтоох саналыг хүргүүлсэн байна.

Ашиглалтад орсон барилгыг бүртгэл дараах байдлаар бүртгэсэн байна.

- Хүрээмарал сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгыг ТӨБЗГ-ын 2023 оны 06 дугаар 14-ний өдрийн 314 дүгээр тогтоолоор бүртгэсэн.
- Баян-Овоо сумын 150 ортой Цэцэрлэгийн барилга, Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 100 ортой дотуур байрны барилгыг Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар эзэмшигчийг тогтоон бүртгэсэн.
- "Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалт" гүйцэтгэлийн аудитаар Шинэ суурьшлын бүсэд баригдаж 2021 оны 11 дүгээр сард улсын комисс хүлээн авсан 5,166.1 сая төгрөгийн 640 хүүхдийн сургууль ашиглалтад орсон боловч бүртгэлд тусгаагүй байсанд албан шаардлага өгч аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар эзэмшигчийг тогтоож бүртгэсэн.
- 
- Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг эзэмшигч тогтоож, бүртгэлд тусгаахаар тогтоолын төслийг аймгийн ОНӨГ-аас аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Харин 7,028.6 сая төгрөгийн 2 барилгыг бүртгэх шийдвэр гараагүй, байна. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

- Баацагаан сумын ЗДТГ-ын 1,560.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг 2023 онд ашиглалтад хүлээн авсан.
- Баянхонгор сумын Номгон сургуулийн 440 суудалтай 5,467.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургуулийн барилгыг 2022 онд ашиглалтад орсон байхад тус тус данс бүртгэлд тусгаагүй байна
- Баянхонгор сумын усан бассейн спорт цогцолборын барилгыг бүртгээгүй тул санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Биеийн тамир, спортын газарт 8,730.6 сая төгрөг өөр хөрөнгийг бүртгэх албан шаардлагыг хүргүүлсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар төсөвт өртөг нэмэгдсэн байсныг илрүүлсэн тус зөрүү 3,213.8 сая төгрөгийн зөрүүг нэмж бүртгүүлэх албан шаардлагыг өгөө.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4<sup>4</sup>, 6.2<sup>5</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4<sup>6</sup> дэх заалтуудтай нийцэхгүй тул хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, данс бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

УТХО-аар эрх шилжиж ирсэн 90,498.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34,791.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээ буюу Баацагаан, Галуут сумдад хэрэгжсэн сумын төвийн шинэчлэл, хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл, шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ, шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай 10 км авто зам, Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, 110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл зэрэг төсөл, арга хэмжээ дуусаагүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор шинэ суурьшлын бүсийн цэвэрлэх байгууламжийг 735.0 сая төгрөгөөр “Чандмань- Баянхонгор” ХК-д эзэмшүүлэхээр шийдвэрлэсний дагуу хөрөнгөд бүртгэсэн байна.

“Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалт” гүйцэтгэлийн аудитаар гадна холбооны ажил хийгдээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Харин хөдөө аж ахуйн кластер төслийн багц арга хэмжээ нь бүрэн хийгдэж дуусаагүй тул хөрөнгөд бүртгэх шийдвэр гараагүй байна.

УТХО-аар 2,632.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,524.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй тоног төхөөрөмж нийлүүлэх 4 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

*Хүснэгт№ 4. УТХО-аар Баянхонгор аймагт нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж*

<sup>4</sup> - Хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө

<sup>5</sup> - Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

<sup>6</sup> - Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

№	Төсөл, арга хэмжээ	Санхүүжүүлсэн дүн	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Бүртгэсэн эсэх
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж	449.0	Биохимийн шинжилгээний аппарат, мотоцикл	66	Тийм
2	Боловсролын салбарын тоног төхөөрөмж	1,479.0	Компьютер, дижитал танхимын тоног төхөөрөмж	660	Тийм
3	Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж	299.1	Мотоцикл, компьютер, принтер	76	Тийм
4	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмж	403.7	Компьютер, принтер, тавилга, бусад	372	Тийм
	<b>Нийт дүн</b>	<b>2,630.8</b>		<b>1,174</b>	

УТХО-аар Баянхонгор аймагт хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний 1,174 ширхэг 2,630.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгасан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 16 ширхэг мотоцикл нийлүүлэхээс 2.9 сая төгрөгийн 1 ширхэг мотоциклийг нийлүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.
- Өлзийт суманд хуваарилсан Ухаалаг самбар ирэхдээ техникийн гэмтэлтэй ажилладаггүй ирснийг нийлүүлэгч компанид 2023.07 сард буцаан хүргүүлсэн боловч 2024.03.29-ны байдлаар шинээр сольж өгөөгүй байгаа тул өнөөгийн зах зээлийн ханшаар тооцож төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд тоног төхөөрөмжийг дутуу өгсөн, хүлээн авсан мотоциклийн тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшлээр бүртгээгүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 2023 онд нийлүүлэгдсэн 20.0 сая төгрөгийн 7 ширхэг мотоциклийн тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшилд бүртгээгүй байна.
- Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 2023 онд нийлүүлэгдсэн 114.7 сая төгрөгийн 40 ширхэг мотоциклийн тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшилд бүртгээгүй байна.

Дээрх зөрчил нь Авто тээврийн тухай хуулийн 17.1<sup>7</sup>-д дэх заалтыг зөрчсөн тул хөрөнгийг эзэмшилд бүртгэх албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Цаашид хөрөнгийн бүртгэлийг холбогдох газарт асуудлыг тавьж цаг тухай бүрт нь шийдвэрлүүлж байх зөвлөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

<sup>7</sup> - Авто тээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно.

**БҮЛЭГ В. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН ҮҮ?**

**БАЯНХОНГОР АЙМАГТ ХЭРЭГЖИЖ АШИГЛАЛТАД ОРСОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНД АЯ ТУХТАЙ, ТААТАЙ ОРЧИНД 1,906 ХҮҮХЭД СУРЧ, 130 ХҮҮХЭД АМЬДАРЧ, 3,868 ХҮН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АВЧ, ХҮҮХДҮҮД БОЛОН ИРГЭД УСАН БАССЕЙН СПОРТ ЦОГЦОЛБОРТ 10 ТӨРЛИЙН СЕКЦ ДУГУЙЛАНД ХАМРАГДАХ БОЛОМЖ БҮРДСЭН БАЙНА.**

*В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?*

**Баянхонгор аймагт УТХО-аар 2023 онд хэрэгжиж байнгын ашиглалтад орсон 14 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.**

Баянхонгор аймагт УТХО-аар 2023 онд боловсролын салбарт 14,043.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 барилга, соёлын салбарт 1,926.0 сая төгрөгийн 1



барилга, эрүүл мэндийн салбарт 1,463.7 сая төгрөгийн 1 барилга, 1,560.7 сая төгрөгийн ЗДТГ-ын 1 барилга, 11,944.4 сая төгрөгийн усан спорт цогцолборын 1 барилга ашиглалтад орж, 2,632.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний тоног

төхөөрөмж нийлүүлэгдэж, 11,961.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах 6 багц төсөл, арга хэмжээнээс 4 багц төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

Ашиглалтад орсон барилга, хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байгаа боловч ашиглалтын явцад дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал:

Эрдэнэмандал сургуулийн захирал, Политехникийн коллежийн захиралтай 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр “Орон нутгийн өөрийн өмчийн ашиглалтын гэрээ”-г 4 сарын хугацаанд байгуулан нэг сарын түрээсийн төлбөр 5.0 сая буюу нийт 20.0 сая төгрөгөөр Эрдэнэмандал сургуулийн 100 ортой дотуур байрны 8 өрөөнд Политехникийн коллежийн 70 оюутан амьдруулах гэрээ байгуулан түрээсийн төлбөрийг бүрэн авсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

➤ Эрдэнэмандал сургуулийн 100 ортой дотуур байранд тус сургуулийг 130 хүүхэд, политехникийн коллежийн 70 оюутан нийт 200 орчим хүүхэд амьдарч байгаа нь хүүхдүүдийг тав тухгүй, хэт шахуу орчинд амьдрах эрсдэлийг бий болгож байна.

Дээрх зөрчлийг таслан зогсоож, дотуур байрыг нормын дагуу ашиглаж хүүхдүүдийн тав тухтай орчинд амьдарч, хичээл сургуульдаа суралцах боломжоор хангах, Политехникийн коллежийн оюутныг байрлуулах байрыг өөр оновчтой байдлаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газарт хүргүүлэв.

УТХО-аар хийгдэж ашиглалтад орсон зарим барилгад ашиглалтын явцад дараах зөрчил, дутагдал илэрч байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Баацагаан сумын ЗДТГ-ын барилгын ажлыг “Бианконэро” ХХК 1,560.7 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд 2 дугаар давхрын 4 өрөө, 1 дүгээр давхрын 5 өрөөний паар өвлийн улиралд муу халдаг, паарнаас ус алддаг, гаднах шилэн хаалганы дан шилтэй, резингүй, цонхны дуулаалга хийгдээгүй, цонхоор шороо их ордог, 1 давхрын 3 өрөө цахилгаангүй.
- Хүрээмарал сумын ЭМТ-ийн барилгын ажлыг “Зураан даваа” ХХК 1,463.7 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд цэвэр, бохир ус, ариун цэврийн өрөө ашиглалтад ороогүй, цонхны битүүмж муу, далий муруй суугдсанаас өрөөнүүдийн цонхоор шороо ордог, гадна талбайн тохижилт, явган хүний зам, машины зогсоол хийгдээгүй, хэвтэн эмчлүүлэгсдэд гаднын дуу чимээ их сонсогдож байгаа учир тав тух муутай.
- Баян-Овоо сумын 150 ортой Цэцэрлэгийн барилгын ажлыг “Зүүн шанд” ХХК 2,042.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд шилэн хаалга бүрэлдээ салсан, 1,2 дугаар давхрын хана өнгөн хэсэгтээ хагарсан, 3 цонх хагарсан, дээврийн цас хайлснаас багш хөгжлийн төвийн өрөөний таазаар ус нэвтэрсэн.
- Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 100 ортой дотуур байрны барилгын ажлыг “Жамъянпайтан” ХХК 1,317.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд барилгын 5 том цонх, 31 жижиг цонх, аваарын шилэн хаалга хагархай, хана цуурсан, агааржуулалтын хоолой ажилладаггүй.
- Усан бассейн спорт цогцолборын барилгын ажлыг “РМВ” ХХК 11,944.4 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд цонх болон шилэн пассат дулаан алддаг, дээврийн усны хаялгыг даган граж болон подволруу ус алддаг, дулааны шугам сүлжээг өргөтгөх шаардлагатай.

Дээрх хангалтгүй, чанаргүй хийгдсэн ажлуудыг гүйцэтгэгч компаниар засварлуулж, зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Цаашид хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажилд тавих хяналтыг сайжруулан ашиглалтад орсон барилгад баталгаат хугацаанд багтаан дахин хяналтыг хийж байх зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар Усан бассейн спорт цогцолборт мэргэжлийн багш дасгалжуулагч, эмч холбогдох мэргэжилтэн байхгүйгээс ажиллахгүй байсан тул албан шаардлага хүргүүлж хэрэгжилт хангагдаж усан бассейн мэргэжлийн багш дасгалжуулагчтай болж хэвийн ажиллаж аудитын үр нөлөө гарсан байна.

**В.2. УТХО-аар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, зарим төсөл, арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн байна.**

Баянхонгор аймагт 2023 онд боловсролын салбарт 100 ортой 1 дотуур байр, 1,080 суудалтай 2 сургууль, 150 ортой 1 цэцэрлэг ашиглалтад орсноор хүүхдийн хамрагдалт 35.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт № 5. УТХО-аар боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт*

№	Төсөл, арга хэмжээ	Хичээлийн жил		
		2021-2022	2022-2023	2023-2024
1	Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн дотуур байр (100 ортой)	0	93	130
2	Баянхонгор сумын Гэгээн сумади сургууль (640 суудал)	0	348	491

3	Баянхонгор сумын Номгон сургууль (440 суудал)	1,338	1,245	1,182
4	Баян-Овоо сумын цэцэрлэг (150 ортой)	52	65	87
	<b>Нийт дүн</b>	<b>1,390</b>	<b>1,751</b>	<b>1,890</b>

Баянхонгор аймагт УТХО-аар хэрэгжиж ашиглалтад орсон төсөл, арга хэмжээнээс дараах үр өгөөж гарч байна. Тухайлбал:

✓ Усан бассейн спорт цогцолборын барилга ашиглалтад орсноор улсын болон орон нутгийн шинж чанартай биеийн тамир, их спорт, олон нийтийг хамарсан 60 гаруй арга хэмжээ зохион байгуулагдснаас гадна орон нутагт анх удаа Монголын хүүхдийн спортын зуны VII дугаар их наадмын анхан шатны болон шигшээ тэмцээн 23 төрлөөр зохион байгуулагдаж нийт давхардсан тоогоор 45,000 мянган хүүхэд, залуучууд, ард иргэд хамрагдсан байна. Мөн өмнө нь спортын 8 төрлийн секц дугуйлан хичээллэдэг байсан бол 10 төрлөөр секц дугуйлан хичээллэж нийт 800 гаруй хүүхэд хамрагдаж, 11 орон тоо шинээр нэмж баталсан байна.

✓ Шинэ суурьшлын бүсийн 640 хүүхдийн сургууль, 90 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор ашиглалтад орсноор шинээр ажлын байр бий болж, 102 багш, ажилтантай, сургууль 481 сурагчтай, цэцэрлэгийн 4 бүлэгт 146 хүүхэд хамрагдаж, орон нутгийн орлогод цалин, хөлс түүнтэй адилтгах орлогын татварт 137.9 орчим сая төгрөгийг жил бүр төвлөрүүлсэн байна.

✓ Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 100 ортой дотуур байр ашиглалтад орсноор тус сургуулийн хүүхдийн тоо нэмэгдсэнээс гадна хөдөөгийн хүүхдүүд тохилог, дулаан орчинд хичээл сургуульдаа шамдан суралцах боломжтой болсон байна.

✓ Хүрээмарал сумын 240 суудалтай Соёлын төвийн барилга ашиглалтад орсноор албан хаагчдын ажиллах таатай орчин бүрдсэн, хурал, зөвлөгөөн, урлагийн тоглолт, чуулга уулзалт зэрэг 105 арга хэмжээг зохион байгуулж 13,929 хүнд хүрч үйлчилсэн байна. Түүнчлэн морин хуурын дугуйланд 30, бүжгийн дугуйланд 37, морь бөхийн цол дуудах сургалтад 67 хүүхэд хамрагдаж, 24 ардын авьяастан иргэдэд магтаал зааж сургасан байна.

✓ Баацагаан сумын ЗДТГ-ын барилга 2023 оны 11 дүгээр сард ашиглалтад орсноор сумын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх ая тухай орчин бүрдсэн, ажилтан, албан хаагчид стандартад нийцсэн ажлын байранд ажилласнаар ажлын бүтээмж сайжирсан, мэдээллийн танхимтай болж техник хэрэгслээр хангагдсанаар иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл, сургалт хийх боломж бүрдсэн байна.

✓ Баян-Овоо сумын цэцэрлэг нь 2014 оноос хойш 2 бүлэгтэй, 52 хүүхэд, 10 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байсан бөгөөд 150 ортой Цэцэрлэгийн барилга ашиглалтад орсноор бэлтгэл, ахлах, дунд, бага бүлгүүдэд 02-05 насны 70-80 хүүхэд хүлээн авч, 18 албан хаагчтайгаар хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Цаашид тус байгууллагад хамрагдах хүүхдийн тоо өсөх хандлагатай байгаа нь тус хөрөнгө оруулалт нь хэрэгцээ шаардлагыг хангасан төлөвлөсөн үр дүнд хүрэх боломжтой харагдаж байна.

Мөн эрүүл мэнд, боловсрол, соёл, эмэгтэйчүүд, багийн Засаг дарга нарт чиглэсэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн нь тухай салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын ажил болж чадсан байна.

❖ **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

**БҮЛЭГ ОН-А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХОЛБОГДОХ ТООЦООЛОЛ, БАРИМТ БИЧГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛЖ, САНХҮҮЖҮҮЛСЭН ҮҮ?**

**ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЖАГСААЛТАД БАГТСАН 5 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЭЗҮ ХИЙГЭЭГҮЙГЭЭС САНХҮҮЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

*ОН-А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан уу?*

**Баталсан төсөл, арга хэмжээнээс 5 сумын зам засварын ажил нь төлөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийх арга хэмжээний саналыг сумд болон төсөвт байгууллага, ИТХ-ын ажлын албанаас намын бүлгүүдийн саналыг аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэс хүлээн авч эрэмбэлэн төлөвлөгөөнд тусган ажилласан байна.

Хөгжлийн төлөвлөгөөнд ирүүлсэн саналыг жагсаалт гарган мөнгөн дүнг тусган ирүүлж байгаа төсөвт өртгийн тооцоо, судалгааг иж бүрэн ирүүлээгүй нь төлөвлөлт үндэслэлтэй эсэхийг аудитаар нотлох боломжгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Баянлиг, Баянговь сумдын зам засварт тус бүр 20.0 сая нийт 100.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ хийгдээгүй байхад замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2022.12.02 өдрийн 12/55 тоот тогтоолоор баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4<sup>8</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

ТЭЗҮ хийгээгүйгээс шалтгаалан дээрх 5 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Иймд цаашид хөрөнгө оруулалтын жагсаалтад ТЭЗҮ хийсэн төсөл арга хэмжээг тусгаж батлуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгөв.

*ОН-А.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?*

**Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан 5 ажлын төсөвт өртөг үндэслэлгүй, нийт ТАХ-ны санхүүжих дүнгийн 94.0 хувийг тайлант онд санхүүжүүлэхээр тусгасан нь бүрэн хэрэгжих бололцоотой байна. Өмнөх оноос шилжүүлэн хэрэгжүүлж буй 9 төсөл, арга хэмжээг бүрэн тусгаж баталсан байна.**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр барилга байгууламжийн их засварын ажлаас өмнөх оноос шилжиж ирсэн 1,960.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл

<sup>8</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

арга хэмжээг хэрэгжүүлж дуусгахаар 1,085.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Харин 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 10 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ нь дараа онд шилжихээр баталсан бөгөөд 2023 онд тус арга хэмжээнүүд нь 47.3-78.1 хувиар санхүүжихээр баталсан нь дараа оны төсөвт ачаалал үүсгэхээргүй байна.

Хүснэгт № 6 Он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлант онд баталсан	Хувь
1	Эрдэнэцогт сумын Ямаат, Өвгөнжаргалант багийн төвийн засвар	155.0	108.0	69.7
2	Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	148.0	70.0	47.3
3	Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар	91.0	71.0	78.1
	Дүн	394.0	249.0	65.0

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд өмнөх оноос шилжин ирсэн 1 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 105.0 сая төгрөг, тайлант онд шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээнээс 21 төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхээр 1 төсөл арга хэмжээний 98.7 хувийг тайлант онд санхүүжүүлэхээр хэрэгжих бололцоотой байдлаар баталсан байна. Тухайн онд он дамжин хэрэгжихээр томоохон төсөл арга хэмжээ байхгүй байна.

*ОН-А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан уу?*

***Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн бичиг баримтад заасан ерөнхий шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.***

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр тодотгон баталсан байна.

Төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 513.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 369.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 1,217.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 6, харьцуулалтын аргаар 7 тендрийг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хооронд төсөл,

арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулжээ.

Заг сумын модон гүүрний засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг төлөвлөсөн хугацаанаас хоцроож зарласан бөгөөд энэ талаар аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тайлбар авахад “аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтсээс ТЭЗҮ болон зарлах хүсэлтийг ирсэн даруйд буюу 2023.03.10-ны өдөр харьцуулалтын аргаар тендерийг зарласан боловч 2023.03.16-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад техникийн гэмтэл гарч тендер шалгаруулалтын мэдээлэл устсан, Худалдан авах ажиллагааны газраас өгсөн чиглэлийн дагуу дахин зарласнаас хугацаа хоцорсон” гэсэн тайлбарыг ирүүлэв.

Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж цахим системд тендерийн урилга, үр дүнг тухай бүр оруулсан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээн гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажилласан байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,796.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,698.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 худалдан авах ажиллагаа зарлаж 1,759.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнгээр бага үнийн саналаар шалгарч 36.5 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцлийг бүрдүүлсэн байна.

**Хүснэгт№ 7 Орон нутгийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа**

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Тайлант оны санхүүжилт	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын журам
<b>Их засварын зардал</b>					
1	5, 12-р цэцэрлэгийн их засвар	80.0	80.0	78.9	Харьцуулалтын арга
2	Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	148.0	70.0	146.4	Нээлттэй тендер шалгаруулалт
3	Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар	91.0	71.0	89.7	Харьцуулалтын арга
4	Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох	40.0	40.0	40.0	Харьцуулалтын арга
<b>Замын сангийн зардал</b>					
5	Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх	220.0	220.0	219.9	Нээлттэй тендер шалгаруулалт
6	Соого сейкео сургуулийн арын уулзвараас арван	240.0	240.0	222.0	Нээлттэй тендер шалгаруулалт

	мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх					
7	Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу дугуйн зам хийх	220.0	220.0	210.2	Нээлттэй тендер шалгаруулалт	
8	Өлзийт сумын Гялгарын давааг засварлах	50.0	50.0	47.9	Харьцуулалтын арга	
9	Галуут сумын Сүмбэрийн багийн замыг засварлах	150.0	150.0	149.8	Харьцуулалтын арга	
10	Баянхонгор сумын шаардлагатай газруудад явган хүний зам байгуулах	197.0	197.0	196.3	Нээлттэй тендер шалгаруулалт	
11	Заг сумын модон гүүрний засвар	60.0	60.0	59.4	Харьцуулалтын арга	
12	Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх	80.0	80.0	80.0	Харьцуулалтын арга	
<b>Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал</b>						
13	Аймгийн ИТХ-ын ажлын албанд шаардлагатай автомашин	220.0	220.0	219.0	Нээлттэй тендер шалгаруулалт	
<b>Нийт дүн</b>		<b>1,796.0</b>	<b>1,698.0</b>	<b>1,759.5</b>		-

Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох ажлыг, Баянхонгор сумд аймгийн төв доторх эвдэрсэн тайлбайд замын нөхөөс хийх ажлыг хэрэгжүүлэх эрхийг тухайн сумдад шилжүүлсэн байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 6 тендер зарласнаас 4 тендерт “хамгийн сайн” үнэлэгдсэн оролцогч нартай гэрээ байгуулсан.

Баянхонгор сумын явган хүний зам байгуулах, аймгийн ИТХ-ын ажлын албанд шаардлагатай автомашин худалдан авах тендерийг 2 удаа зохион байгуулахад шаардлага хангасан оролцогч ирээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь хэсэгт заасны дагуу шууд гэрээ байгуулсан байна.

*ОН-А.4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?*

***Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олгосон байна.***

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барилга, байгууламжийн их засварын ажлаар хийж гүйцэтгэсэн нийт 2,543.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл арга хэмжээнд 1,523.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж гүйцэтгэлээр 1,522.6 сая төгрөгийг олгожээ.

**Хүснэгт № 8 Төсөл, арга хэмжээний санхүүжилт**

№	Төсөл арга хэмжээний нэр	Баталсан санхүүжилт	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувиллын төв болгох	251.3	251.9	(0.6)
2	Заг сумын ЭМТ-ийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах	39.8	39.8	-

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3	Богд сумын ЕБС-ийн барилгын засвар хийх	123.4	83.4	40.0
4	Дөвөнтийн заалны их засвар хийх	86.3	126.3	(40.0)
5	Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн их засвар	150.3	150.3	-
6	Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн их засвар	180.0	180.0	-
7	Баян-Овоо сумын дотуур байрны их засвар	149.9	149.9	-
8	Жаргалант сумын сургуулийн их засвар	104.0	104.0	-
9	Зэвсэгт хүчний 103 дугаар тусгай ротын барилгын гадна засвар хийх	20.0	20.0	0.1
10	Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай ротын сантехник, дулааны шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх	20.0	20.0	0.1
11	Баянхонгор сумыг тойрсон ногоон байгууламжийг услах гүний худгуудыг цахилгаан хангамжид холбох ажлын материалын зардал	13.0	13.0	0.0
12	5, 12-р цэцэрлэгийн засвар	80.0	78.9	1.1
13	Эрдэнэцогт сумын Ямаат багийн төвийн засвар	108.0	108.0	-
14	Богд сумын хүн эмнэлгийн ариун цэврийн байгууламжийн оролцооны үлдэгдэл	16.2	16.2	-
15	Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох	40.0	40.0	-
16	Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	70.0	70.0	-
17	Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар	71.0	71.0	-
	Нийт дүн	1,523.2	1,522.6	0.6

Барилга байгууламжийн их засварын жагсаалтад “Дөвөнтийн заалны их засвар хийх” арга хэмжээнд 40,0 сая төгрөгийг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг зөрчсөн тул алдаа зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн байна.

Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж, ахмадын амралт сувиллын төв болгох төсөл арга хэмжээнд 251.3 сая төгрөг баталсан байхад 251.9 сая төгрөг буюу 0.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн нь дээрх аудитаар илэрч төлбөрийн акт тогтоосон байна.

Автозамын сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр 1,543.9 сая төгрөгийг баталсан ба нийт 1,375.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №9 Авто замын сангийн ТАХ-ний санхүүжилт

№	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	2023 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Зөрүү
1	Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх	105,000.0	103,602.4	1,397.6
2	Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх	80,000.0	80,000.0	-

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3	Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх	220,000.0	215,756.6	4,243.4
4	Соого сейко сургуулийн арын уулзвараас арван мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих, босоо хашлага хийх	236,855.0	222,000.0	14,855.0
5	Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу дугуйн зам хийх	220,000.0	210,183.4	9,816.6
6	Аймгийн төвд стандартын шаардлага хангасан хурд сааруулагч байршуулах	20,000.0	20,000.0	-
7	Хөгжимт драмын театр явган хүний гарцыг стандартын дагуу тохижуулах	20,000.0	20,000.0	-
8	5-р сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах	20,000.0	20,000.0	-
9	Номундалай цогцолбор сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах	20,000.0	20,000.0	-
10	"Номгон" ахлах сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах	20,000.0	20,000.0	-
11	Эрдэм ахлах сургууль хүртэлх шороон замыг засварлах	15,000.0	-	15,000.0
12	Зам арчилгаанд давс худалдан авах	20,000.0	20,000.0	-
13	Чандмань-Баянхонгор ХК-ний авто зогсоол	20,000.0	20,000.0	-
14	Өлзийт сумын Гялгарын давааг засварлах	50,000.0	47,872.6	2,127.4
15	Галуут сумын Сүмбэрийн багийн замыг засварлах	100,000.0	99,833.4	166.6
16	Баян-Өндөр сумын зам засвар	20,000.0		20,000.0
17	Баянцагаан сумын зам засвар	20,000.0		20,000.0
18	Шинэжинст сумын зам засвар	20,000.0	-	20,000.0
19	Баянлиг сумын зам засвар	20,000.0	-	20,000.0
20	Баянговь сумын зам засвар	20,000.0	-	20,000.0
21	Баянхонгор сумын шаардлагатай газруудад явган хүний зам байгуулах	197,000.0	137,011.5	59,988.5
22	Шаргалжуут багийн зам засвар	20,000.0	20,000.0	-
23	Заг сумын модон гүүрний засвар	60,000.0	59,399.8	600.2
	<b>Дүн</b>	<b>1,543,855.0</b>	<b>1,375,659.6</b>	<b>168,195.4</b>

Дээрх 23 төсөл арга хэмжээнээс нийт 75.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс санхүүжилт олгоогүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Баян-Өндөр, Баянцагаан сумын зам засварын ажлын 20,0 сая төгрөгийн ажил эхлээгүй байхад санхүүжилтийн 40,0 сая төгрөгийн барьцаа дансанд байршуулсан байгаа тул тус хөрөнгийг замын сангийн дансанд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**БҮЛЭГ ОН-Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ, ХҮЛЭЭН АВСАН УУ? ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАН АЖИЛЛАСАН БАЙНА.**

*ОН-Б.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?*

**Баянбулаг, Жаргалант сумдын 2 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл дутуу, Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны их засварын ажил чанаргүй гүйцэтгэсэн байна.**

Барилга байгууламжийн их засварын ажлын төлөвлөгөөнд нийт 2,543.7 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлснээс 2,355.7 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн байна.

Харин Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох ажилд 40.0 сая, Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах 148.0 сая төгрөгийн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусаагүй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

➤ *Баян-Овоо сумын дотуур байрны их засварыг 249.9 сая төгрөгөөр “Есөн од констракшн” ХХК хийж хүлээлгэн өгсөн боловч дотор ханын засал зарим хэсгээрээ ховхорсон, шатны будаг, паркетан шалыг чанаргүй хийсэн, засварын ажлыг бүхэлдээ чанар муутай хийсэн байна.*

Иймд дээрх ажлыг гүйцэтгэгчээр дахин засварлуулан гүйцэтгүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Замын сангаар хийсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн байршилд бүрэн хийж хэрэгжүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр хийсэн 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дотор эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажил нь 1,505.5 м<sup>2</sup> талбайд нөхөөс хийж гүйцэтгэл гаргасан байна.

Аудитын хугацаанд нөхөөс хийсэн замуудыг үзэхэд аймгийн Цагдаагийн газраас арван мянгатын гэрлэн дохио хүртэлх авто зам, хас сэлбэгийн дэлгүүрийн хажуугийн авто зам, Цэлмэг өглөө дэлгүүрээс Дэлгэрэх зах хүртэлх авто зам хагарч эвдэрсэн байна.



Цагдаагийн газраас арван мянгатын гэрлэн дохио хүртэлх зам

Замын нөхөөс хийх зардалд орон нутгийн төсвөөс жил бүр төсөв баталж байгаа ч аудитын явцад шалгахад замын эвдрэл гэмтэл их байгаа нь хөрөнгийн үр ашиг бүрэн гараагүй, төсөв үргүй зарцуулагдсан байх эрсдэлтэй байна. Гэвч дээрх замын эвдрэл гэмтэл нь өмнө нь засварлагдсан эсэх эсвэл шинээр үүссэнийг нотлох боломжгүй байна.

Иймд төсвийн хөрөнгөөр хийж буй замын нөхөөсөнд тэмдэг тэмдэглэгээ хийж эвдрэл гарсан тохиолдолд гүйцэтгэгчээр засварлуулж байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст хүргүүлэв.

*ОН-Б.2. Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан уу?*

**Захиалагчийн хяналтаар өгсөн даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлагыг цаг тухайд нь тооцохгүй байгаагаас зөрчил, дутагдал арилахгүй байна.**

Аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн их засварын ажлуудад хяналт хийсэн байна.

Хяналтаар ажлын зураг төсөвт заасан шаардлага, норм дүрмийн дагуу их засварын ажлын явцыг шалган илэрч буй зөрчил дутагдлыг арилгах үүрэг даалгавар, зөвлөмж, зөвлөгөө өгч өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайланг гаргуулан авч ажилласан боловч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс зөрчил дутагдал, илэрч байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

➤ Хяналтаар өгсөн даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлагыг цаг тухайд нь тооцохгүй байгаагаас Баян-Овоо сумын дотуур байрны их засварын ажил хангалтгүй, чанар муутай хийгдсэнээс тус байранд амьдарч байгаа сурагчид ая тухгүй орчинд амьдрахаас гадна төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Иймд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг чанартай хэрэгжүүлж, гүйцэтгэгч нарт тухай бүрд хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Замын сангийн хөрөнгөөр Баянхонгор аймагт хэрэгжсэн 14 төсөл арга хэмжээнд, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн авто зам (тээвэр)-ын хяналтын улсын ахлах байцаагч, ХБТХО-ын хэлтсийн мэргэжилтэн нарт хамтран авто замын арчлалт, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэсэн 11 аж ахуйн нэгж байгууллагад 1-2 удаагийн давтамжтай урьдчилан сэргийлэх шалгалтыг хийсэн бөгөөд хяналтаар илэрсэн зөрчил дутагдалд шалгалтын тэмдэглэл үйлдэн үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврын биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулсан байна.

Баянхонгор аймагт замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад замын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага ордоггүй тул барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага орж гэрээ байгуулснаас мэргэжлийн инженер техникийн ажилтан дутмагаас ажлын чанарт муугаар нөлөөлөх эрсдэл үүсэж байна.

**ОН-Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаасан уу?**

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.**

Баянхонгор аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,498.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан байна. Үүнээс:

- Их засварын зардлаас 2,355.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,413.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 851.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор хөрөнгөд эзэмшигч тогтоон холбогдох байгууллагууд хөрөнгөдөө орлого авч бүртгэсэн;
- Шууд зардлаар 52.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг тайлагнасан;
- Аймгийн ОНӨГ 251.3 сая төгрөгийн 1 төсөл арга, хэмжээний эзэмшигчийг тогтоох саналыг аймгийн Засаг дарга хүргүүлсэн;
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 257.9 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй
- Тайлант онд хэрэгжих 188.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 110.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 2 төсөл, арга хэмжээ дуусаагүй

**Их засварын зардлаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг хөрөнгөд бүртгэсэн байдал (сая төгрөг)**



**Аудитын илрүүлэлт:**

➤ Баян-Овоо сумын дотуур байрны их засварыг 249.9 сая төгрөгөөр “Есөн од констракшн” ХХК, Эрдэнэцогт сумын Ямаат багийн төвийн барилгыг 155.0 сая төгрөгөөр “Баянхонгор эко дулаан” ХХК тус тус хийж гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан байхад хөрөнгөд бүртгээгүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 , 6.2 , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтуудтай нийцэхгүй тул хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, данс бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Замын сангийн зардлаар 1,868.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,468.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж аймгийн ИТХ-ын хурлын тогтоолоор дараах төсөл, арга хэмжээг орлого авч бүртгэсэн байна.

- Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хуртэлх автозам дагуу явган хүний зам хийх
- Соого сейкео сургуулийн арын уулзвараас арван мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх
- Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хуртэлх автозам дагуу дугуйн зам хийх
- Аймгийн төвд стандартын шаардлага хангасан хурд сааруулагч байршуулах
- Хөгжимт драмын театр явган хүний гарцыг стандартын дагуу тохижуулах
- Чандмань-Баянхонгор ХК-ний авто зогсоол
- Заг сумын модон гүүрийн засвар


Аймгийн ИТХ-ын хурлын тогтоолоор дараах төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын зардлаар тайлагнасан байна.

- Өлзийт сумын Гялгарын давааг засварлах
- Галуут сумын Сүмбэрийн багийн замыг засварлах
- Шаргалжуут багийн зам засвар

Аймгийн ОНӨГ-аас хөрөнгийн эзэмшигчийг тогтоож бүртгэх саналыг аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

- 5-р сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах
- Номундалай цогцолбор сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах
- "Номгон" ахлах сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах
- Баянхонгор сумын шаардлагатай газруудад явган хүний зам байгуулах

Их засварын зардлаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг хөрөнгөд бүртгэсэн байдал (сая төгрөг)



Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Баянлиг, Баянговь сумдын зам засвар, Эрдэм ахлах сургууль хүртэлх шороон замыг засварлах ажлууд хийгдээгүй, аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метр хатуу хучилттай авто замыг шинэчлэх төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй, зам арчилгаанд худалдан авсан 20.0 сая төгрөгийн давсыг “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бараа материалын тайланд орлого авч зарлагдсан, аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажлыг шууд зардлаар тайлагнасан байна.

### **Аудитын илрүүлэлт:**

- Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх ажил хийгдэж улсын комисс хүлээн авсан байхад данс бүртгэлд бүртгээгүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтуудтай нийцэхгүй тул хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, данс бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар 274.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд бүртгэл тайланд тусгасан байна.

### **БҮЛЭГ ОН-В. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН ҮҮ?**

#### **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙЖ БҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БОДИТ ҮР ДҮНГЭЭ ӨГЧ БАЙНА.**

*ОН-В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?*

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний 86.2 хувийг хэвийн ашиглаж байна.**

Баянхонгор аймагт 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн дараах төсөл арга хэмжээнүүд ашиглалтад орсон байна. Үүнд:

- Боловсролын салбарт 1,344.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 858.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 барилга;
- Эрүүл мэндийн салбарт 454.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 307.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 барилга;
- Зэвсэгт хүчний салбарт 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилга;
- Бусад салбарт 517.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 207.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээнд их засвар;

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр их засвар хийгдсэн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч ашиглалтын шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээ илэрч байна.

### **Аудитын илрүүлэлт:**

- Богд сумын ЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийн ажлыг "Түйн долгио" ХХК гүйцэтгэсэн бөгөөд ашиглалтад орсон ариун цэврийн байгууламж нь өвлийн улиралд гаднах цэвэр болон бохир усны шугам нь хөлдсөний улмаас ашиглахгүй болсон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж ашиглалтад орсон ариун цэврийн байгууламжийг цаашид тасралтгүй ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллагааг хэвийн болгох албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст хүргүүлэв.

### Аудитын үр өгөөж

Галуут сумын эрүүл мэндийн төвийн хуучин халдвартын эмнэлгийн барилгад их засвар хийснээр өмнөх оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалт”-ын аудитаар аймгийн ЭМГ-т өгсөн зөвлөмжийн дагуу ашиглалтгүй байсан шүдний эмнэлгийн тоног төхөөрөмжийг байрлуулан 2024 оны 1 дүгээр улирлаас эхлэн шүдний тусламж үйлчилгээг сумын ард, иргэдэд үзүүлж байна.

*ОН-В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?*

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрч, иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.**

Баянхонгор аймагт 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсролын салбарын 7 барилгад 1,093.7 сая төгрөгийн их засвар хийгдснээр 1,441 хүүхдийн ая тухтай орчинд амьдарч сурч боловсрох нөхцөл бүрдсэн байна.

#### Хүснэгт№ 10. Боловсролын салбарт хийсэн хөрөнгө оруулалт

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Хүүхдийн тоо
1	Богд сумын ерөнхий боловсролын сургууль	158.8	531
2	Баянхонгор сумын 4-р цэцэрлэг	350.0	144
3	Баянхонгор сумын 5, 12-р цэцэрлэг	80.0	407
5	Богд сумын цэцэрлэг	91.0	163
6	Баян-Овоо сумын дотуур байр	249.9	116
7	Жаргалант сумын дотуур байр	164.0	80
	<b>Нийт дүн</b>	<b>1,093.7</b>	<b>1,441</b>

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр барилга байгууламж их засварт орсноор дараах үр дүн гарсан байна. Тухайлбал:

- ✓ *Богд сумын ЕБС-ийн ховхорсон, нурсан ханыг засварлаж, цонхны хагарсан шилийг нөхөж бүтэн болгосноор барилгын гадаад өнгө үзэмж сайжирсан, мөн ангиудын агааржуулатыг сайжруулж, дээврээс ус гоожихгүй болсноор анги танхимын мөөнгөнцөр арилсан, цонх, хана, дээврийн дулаан алдалт буурсан нь хүүхдийн эрүүл, аюулгүй байдал хангагдаж сурч боловсрох таатай орчин бүрдсэн байна.*
- ✓ *Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгт их засвар хийгдэж өрөө тасалгааны цонх, хаалгыг сольсон, барилгын дотор талын хана, тааз, шалыг завсарласан, халаалтын шугам бүрэн шинэчлэгдсэн нь хүүхдийн сурч хөгжих, багш, ажилтнуудын ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэн байна.*
- ✓ *Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгт барилгын гадна бохирын засвар, усан хангамжийн засвар хийгдэж хий авагч суульлуулсан, радиаторуудыг угааж цэвэрлэх, будах ажлууд хийгдснээр цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.*
- ✓ *Эрдэнэцогт сумын Ямаат багийн төвд засвар хийгдснээр тус багийн 766 иргэн төрийн үйлчилгээг хүргэх орчин сайжирч, иргэдийн нийгмийн үйл ажиллагаанд оролцох идэвх нэмэгдсэн байна.*
- ✓ *Баянхонгор сумын Дөвөнтийн зааланд их засвар хийгдснээр үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжирч бокс, хөл бөмбөг, хөнгөн атлетикийн секц дугуйлан хичээллэж 140 гаруй хүүхэд хамрагдаж байна. Мөн багийн иргэд долоо хоногт 2 удаа стортоор хичээллэж байна.*

✓ Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг их засварт оруулснаар 2024 оны 1 дүгээр улиралд шүдний тусламж үйлчилгээг 517, сэргээх засах эмчилгээ үйлчилгээг 637 иргэнд тус тус үзүүлсэн байна.

✓ Жаргалант сумын сургуулийн дотуур байрны галт тогооны засвар, зэвсэгт хүчний 103 дугаар ротын барилгын гадна засвар, зэвсэгт хүчний 143 дугаар тусгай ротын сантехник, дулааны шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, Богд сумын цэцэрлэгийн барилгын гадна засварын ажил хийгдэж ашиглалт хэвийн байна.

Их засвар хийгдэж ашиглалтад орсон барилга байгууламжаас Заг сумын ЭМТ-ийн халдвартын эмнэлэг, Бууцагаан сумын хуучин сургуулийг ашиглаж эхлээгүй бөгөөд цаашид хөрөнгийг ашиглаж үр дүн гаргах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 8.219.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 49.7 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,069.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 100.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-оОо-

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 131,153.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 45,192.7 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг эрх шилжүүлснээс 30,801.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 барилга ашиглалтад орж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт дундаж гүйцэтгэл 81.4 хувьтай байна.
2. Төсвийн тухай хуулийг зөрчин ТЭЗҮ хийгээгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээг баталснаас төсвийн ачаалал нэмэгдэх, хэрэгжүүлэх үе шат хүндрэл учрах эрсдэл үүсэж байна.
3. Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжсэн 22 төсөл, арга хэмжээнээс 3 нь гүйцэтгэгч ажлаа дутуу хийснээс шалтгаалан 3,956.5 сая төгрөгийн санхүүжих боломжийг алдсан байна.
4. Төсөл арга, хэмжээнд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч гүйцэтгэгчийн гаргасан зөрчил дутагдалд хариуцлага тооцохгүй байгаагаас ажлыг чанаргүй хийх байдал давтагдан гарч байна.
5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалтаар засварласан 2 барилга ашиглалтгүй байна.
6. Баянхонгор аймагт хэрэгжиж ашиглалтад орсон хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд ая тухтай, таатай орчинд 1,906 хүүхэд сурч, 130 хүүхэд амьдарч, 3,868 хүн эрүүл мэндийн болон соёлын үйлчилгээг авч, хүүхдүүд болон иргэд усан бассейн спорт цогцолборт 10 төрлийн секц дугуйланд хамрагдах боломж бүрдсэн байна.

-oOo-

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:**

1. Цаашид хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулдаг байдлыг таслан зогсоох
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд төлөвлөсөн ажлыг гүйцэтгэгчээр бүрэн гүйцэтгүүлж, санхүүжүүлэхээр баталсан эх үүсвэрийг бүрэн ашиглахад анхаарч хяналтыг сайжруулах.

### **ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХИШИГБААТАР ТАНАА:**

1. Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажилд тавих хяналтыг сайжруулан ашиглалтад орсон барилгад баталгаат хугацаанд багтаан дахин хяналтыг хийж байх.
2. Ингэний сүүний үйлдвэрийн барилгын хөрөнгө оруулалтын нэмэгдсэн өртгийг мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх.

### **ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА:**

1. Цаашид Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэлийн асуудлыг холбогдох газарт тавьж цаг тухай бүрд нь шийдвэрлүүлж байх.
2. Их засвар хийгдэж ашиглалтад орсон Заг сумын ЭМТ-ийн халдвартын эмнэлэг, Бууцагаан сумын хуучин сургуулийг ашиглаж эхлээгүй бөгөөд цаашид хөрөнгийг ашиглаж үр дүн гаргахад арга зүйгээр хангаж ажиллах

### **ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА:**

1. Хяналтаар өгсөн даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт Зөрчлийн тухай хуулиар тухай бүрд хариуцлага тооцож ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-oOo-

## ҮАГ-ын Гүйцэтгэл, Нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дунд хугацаанд жигд хуваарилах бодлого барьж ажиллах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүргүүлэх.
2. Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ болон Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/, Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ арга хэмжээнүүдэд хөндлөнгийн шинжээч ажиллуулах шаардлагатай.
3. Баянхонгор аймагт хэрэгжсэн эрх шилжсэн 3 ТАХ, эрх шилжээгүй 1 ТАХ Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд санхүүжих дүн бүрэн баталж дууссан боловч одоогийн байдлаар бүрэн хэрэгжээгүй барилга угсралтын ажил өнөөг хүртэл дуусаагүй байна. Үүнд:

### Эрх шилжсэн

- Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/-“Навтгар хайрхан” ХХК
- Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/ “Энх баялаг констракшн” ХХК
- Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ - “Стандарт тоосго” ХХК

### Эрх шилжээгүй

- Дотуур байрын барилга, 150 ор /Баянхонгор, Богд сум/-“Хорол багана констракшн” ХХК

Дээрх төсөл арга хэмжээнүүд нь хэрэгжиж эхэлснээс хойш удааширч, гүйцэтгэл зогссон тул Боловсролын яам, Барилга хөгжлийн төв, холбогдох хууль хяналтын байгууллагын түвшинд асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 969 толгой малаас 189 толгой мал хорогдсон мэдээллийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн ба тус төсөл арга хэмжээ нь аймгийн ТЕЗ-д эрх шилжиж ирээгүй тул гүйцэтгэлийн аудитын тайлангийн нэгтгэлд авч үзэх шаардлагатайг уламжилж байна

-oOo-